



НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Байгууллагын өмч хамгаалах
байнгын зөвлөлийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, Төрийн өмчийн хорооны 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 232 дугаар тогтоол, төвийн хамт олны 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих "Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч	Ахлах арга зүйч
Гишүүд	Нягтлан бодогч Нярав Жижүүр
Нарийн бичгийн дарга	Сэтгэлзүйч

2. Байгууллагын ажилтнуудтай "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ" байгуулж, Төвийн өмч хөрөнгийг зөв зохистой, ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж, удирдлагаар ханган, өмч хөрөнгийн харилцаатай хууль тогтоомжийг сурталчлах, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, байгууллагаас өмч хөрөнгөтэй холбоотой гарсан тушаалын хэрэгжилтийг хангуулахад анхааран, шаардлага тавьж ажиллахыг Өмч хамгаалах зөвлөлд үүрэг болгосугай.

3. "Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн ажиллах журмыг 1 дүгээр, "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ"-г 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн батлах тухай 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/34 дугаартай тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Ш.МӨНХЦЭЦЭГ



313000023

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2022 оны 08 сарын 15 ны өдрийн
4/18 тушаалын дүгээр хавсралт



Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтыг үндэслэн томилогдсон Өмч хамгаалах байнгын зөвлөл нь энэ журмыг мөрдөн ажиллана. Өмч хамгаалах зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Хоёр. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн эрх, үүрэг

2.1 Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын эзэмшилд байгаа өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт гаргах, хандив, бэлэг дурсгал, тусламжийн бараа материалд үнэ тогтоох, илүүдэлтэй, ашиглалтын хугацаа нь дууссан буюу эвдэрч гэмтэлд орсны улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх үндсэн үүргийг хүлээнэ.

2.2 Зөвлөл нь 2.1 дэх заалтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомж, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

2.3 Өмч хамгаалах зөвлөл нь эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу эд хөрөнгө акталж устгах явцад хяналт тавьж ажиллана.

2.4 Техник технологийн хоцрогдолд орж зайлшгүй шинэчлэх шаардлагатай эд хөрөнгө, анхны өртгөө бүрэн нөхөөгүй боловч цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгөд дүгнэлт гаргаж саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

2.6 Эд хөрөнгө үрэгдэж алга болсон, ашиглалтын явцад эвдэрч гэмтсэн нь тодорхой этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалсан нь тогтоогдвол уг этгээдээр хохирлыг төлүүлэх саналыг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.

Гурав. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал

3.1 Өмч хамгаалах зөвлөл нь улирал бүр заавал хуралдах бөгөөд шаардлагатай үед нэмэлт хурал зарлаж болно. Гишүүдийн дийлэнх олонхийн бүрэлдэхүүнтэй үед хуралдах бөгөөд тодруулга, санал авах зорилгоор бусад ажилтнаас хуралд оролцуулж болно.

3.2 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын товыг гишүүдэд мэдээлж, хэлэлцэх асуудлын саналыг хүлээн авч нэгтгэн, хурлын тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулан өмч хамгаалах зөвлөлийн баримт бичгийн бүрдлийг хангаж, архивт хүлээлгэн өгөх ажлыг хариуцна.

3.3 Зөвлөлийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд дарга гишүүд гарын үсэг зурж, байгууллагын даргад танилцуулснаар баталгаажна.

3.4 Байгууллагын засвар, үйлчилгээний төлөвлөгөө гарган Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулан батлуулж, хэрэгжүүлэх, хяналт тавих

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2022 оны 07 сарын 25 ны өдрийн
4/18 тушаалын 2 дугаар хавсралт



ЭД ХӨРӨНГИЙН БҮРЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ГЭРЭЭ

20__ оны __ сарын __ өдөр

№__

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г нэг талаас Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төвийн Өмч хамгаалах зөвлөл цаашид "байгууллага" гэх/ нөгөө талаас ажилтан _____ Регистрийн дугаар: _____, цаашид "ажилтан", хамтад нь "талууд" гэх/ нар байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах үндсэн зорилгоор Монгол Улсын Иргэний хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар бүлгийг үндэслэн дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2.Гэрээний зорилго нь ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа хариуцан авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах буюу үрэгдүүлж байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.3.Ажилтны хариуцсан эд хөрөнгийн тооллогын бүртгэл болох гэрээний "Хавсралт 1" болон холбогдох бусад баримт нь гэрээний салшгүй хэсэг мөн.

1.4.Гэрээ нь талууд хөдөлмөрийн гэрээгээр харилцан холбоотой байх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Ажилтны эрх, үүрэг

2.1.Ажилтан нь байгууллагаас түүнд хадгалуулах буюу албан хэрэгцээнд нь ашиглуулах зорилгоор хариуцуулан өгсөн эд хөрөнгөнд хайр гамтай хандаж, хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, аюул ослын нөхцөл байдал үүсч болзошгүй тохиолдлыг байгууллагын захиргаанд цаг тухайд нь мэдэгдэх үүрэгтэй.

2.2.Ажилтан нь хариуцаж буй эд хөрөнгийн хөдөлгөөн, үлдэгдлийн бүртгэлийг тогтоосон журмаар хөтөлж, тайлагнана.

2.3.Ажилтан нь өөрийн хадгалалт, хариуцлаганд буй эд хөрөнгийг тоолоход оролцоно.

Гурав. Байгууллагын эрх, үүрэг

3.1.Байгууллага нь ажилтанд хэвийн ажиллах болон хариуцан авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардагдах нөхцөл, боломжийг бүрдүүлж өгөх үүрэгтэй.

3.2. Байгууллага нь ажилтанд хариуцсан эд хөрөнгийг хүлээн авах, хадгалах, боловсруулах, худалдах, тээвэрлэх, ашиглах болон байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хүлээх хариуцлагын талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг танилцуулна.

Дөрөв. Хариуцлага

4.1. Ажилтан нь дор дурдсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ. Үүнд:

4.1.1 ажилтны хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэрэг болохыг тогтоосон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

4.1.2 хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан ажилтан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид заасан;

4.1.3 дараа тайлан гаргахаар итгэмжлэл буюу бусад баримт бичгээр хүлээн авсан эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг эргүүлж төлөөгүй;

4.1.4 эд хариуцагч биш боловч эрхэлсэн ажилтай нь холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаар олгосон ажлын багаж, хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас зэрэг эд хөрөнгийг үрэгдүүлсэн;

4.1.5 согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаагүй үедээ байгууллагад хохирол учруулсан.

4.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ажилтны ашиглалт, хадгалалтад буй эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд ажилтан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээхгүй.

4.3. Ажилтны буруугаас Байгууллагад учирсан эд хөрөнгийн хохирлын хэмжээг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 136 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлж, төлүүлнэ.

Тав. Бусад

5.1. Гэрээнд талууд харилцан тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт хийж болох ба энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гэрээнд хавсаргаж байна. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдоно.

5.2. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу зохицуулна.

5.3. Гэрээг адил хүчинтэй 2 эх хувь үйлдсэн бөгөөд талууд тус бүрт нэг, нэг хувь хадгалагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ажил олгогчийг төлөөлж:

Ажилтан:

БӨХБЗ-ийн ахлагч
Ахлах арга зүйч